

САНГИЙН САЙД, МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 5 дугаар сарын 9

Дугаар 106/A-79

Улаанбаатар хот

"Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам"-д  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 217/A-161 тоот хамтарсан тушаалын хавсралт "Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам"-ын 4.1; 4.3; 4.4 дэх заалтуудыг дор дурдсанаар тус тус өөрчилсүгэй:

"4.1 ЗГБХҮЦ-ны өгөөж, үнийг дараах томъёогоор тооцно:

ЗГБХҮЦ-ны өгөөжийг дараах томъёогоор тооцно:

$$I = \frac{F - P}{P} * \frac{365}{T}$$

ЗГБХҮЦ-ны өгөөжид суурилсан хямдруулсан үнийг дараах томъёогоор тооцно:

$$P = \frac{F}{\left[1 + I * \left(\frac{T}{365}\right)\right]}$$

$I$  = Үнэт цаасны өгөөжийн хувь, жилээр

$T$  = Үнэт цаасны хугацаа

$F$  = Үнэт цаасны нэрлэсэн үнэ

$P$  = Үнэт цаасны хямдруулсан үнэ"

"4.3 Засгийн газрын бондын купоныг бодит/365 хоногт үндэслэн тооцно."

"4.4 Хуримтлагдсан хүүг дараах томъёогоор тооцно:

$$AI = P_{par} * \frac{I}{365} * (DD - SD)$$

$AI$  - Хуримтлагдсан хүү

$P_{par}$  - Бондын нэрлэсэн үнэ

I – Купоны хувь

SD – Төлбөр тооцооны өдөр

DD – Хүү хуримтлуулж эхлэх өдөр

2. Энэхүү тушаалыг 2014 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар (Б.Нямаа), Монголбанкны Валют, эдийн засгийн газар (Д.Дэлгэрсайхан), Мөнгөний бодлого, судалгааны газар (Д.Болдбаатар), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан), ҮЦТТХТ /Т.Гандулам/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Б.Батцэцэг), Монголбанкны Дотоод Хяналт, Үйл ажиллагааны Эрдэлийн газар (Х.Дэлгэр)-т тус тус үүрэг болгосугай.

